

**“Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын тэмдэглэл.**

№ 0/.

2022 оны 04 сарын 20-ны өдөр

Дархан сум

“Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022.04.20-ны өдрийн 14<sup>00</sup> цагт “Монгол-Алт” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд 155541 ширхэг саналын эрхтэй 3 хувьцаа эзэмшигч оролцлоо. Хурлын ирц 95 %-тай байгаа нь компанийн тухай хуулийн шаардлагыг хангаж байх тул хурлыг эхлүүлэв. Хурлын даргаар Б.Саруулыг сонгов.

Хурлын дарга: Хурлын дэгийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал болох:

1. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны зардлын төсөв, дарга гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүдийг сонгох
5. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх
  - а. Ногдол ашгийн ТУЗ-ийн танилцуулга
  - б. бусад

Хурлын дотоод журмын дагуу Санхүүгийн тайланг ерөнхий ня-бо Д.Бямбажаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайланг хараат бус гишүүн Д.Чулуун нар танилцуулав.

Хурлын дарга: Эдгээр тайлангуудтай холбоотой асуулт, санал хэлж болно гэв.

Хувьцаа эзэмшигч Гүйцэтгэх захирал М.Оюун: Би компанийн гүйцэтгэх захирлын хувьд хэдэн зүйл танилцуулъя. Өнгөрсөн жилийн хувьд цар тахалтай эдийн засгийн хувьд хүнд жил байлаа. Гэсэн ч компани түрээслэгч нарынхаа түрээсийн төлбөрийг зохих хувиар хөнгөлж ирсэн. Цаашид хил гааль нээгдэхгүй бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж байгаа тул түрээслэгч нарын хувьд хүндхэн байх төлөвтэй байна. Компанийн удирдлагын зүгээс эдийн засаг сайжиртал аль болох зардлаа багасгаж ажиллах төлөвлөгөөтэй байна.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Дэлхий дахинд тархсан цар тахалын улмаас хил, гааль хаагдаж, үйл ажиллагаа хязгаарлагдаж хүндхэн жил өнгөрлөө. Гэхдээ цар тахал намжсан ч эдийн засаг хүндхэн байх төлөвтэй. Иймд гүйцэтгэх захирлын хэлсэнчлэн зардлаа аль болох багасгаж ажилласан нь зөв гэж бодож байна.

Хурлын дарга Б.Саруул: Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай. Ингээд гүйцэтгэх захирал М.Оюун товч тайлбар өгнө.

Хувьцаа эзэмшигч гүйцэтгэх захирал М.Оюун: Компани нь 2012 онд Комиссын тооллого хууль өөрчлөгдсөнтэй холбоотой дүрэмээ шинэчилж, одоог хүртэл энэ дүрмийн хүрээнд ажиллаж ирлээ. 2022.02.01-нээс шинэчилэн батлагдсан “Хөдөлмөрийн тухай хууль” тай холбоотой дүрмээ шинэчилэн найруулсан.

Хурлын дарга: Дүрмийн шинэчилсэн найруулгыг дэмжиж байна. Өөр санал хэлэх хувьцаа эзэмшигч байна уу?

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Дэмжиж байна.

Хурлын дарга: Дүрэм шинэчилэгдсэнтэй холбоотой ТУЗ-ийн зардлын төсөв, дарга, гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоон хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх ёстой. Энэхүү шийдвэрийг урьд жилүүдэд олгож байсан цалингийн сангаар батлуулах санал оруулж байна. Та бүхэн санал хүсэлтээ хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч Гүйцэтгэх захирал М.Оюун: Дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Дэмжиж байна.

Хурлын дарга: Миний хувьд дэмжиж байгаа, ингээд дараагийн хэлэлцэх асуудал ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай. ТУЗ-д нэр дэвшигчид хүсэлтээ ТУЗ-ийн нарийн бичигт бичгээр өгсөн. ТУЗ-ийн нарийн бичиг Э.Жавхлантөгс уншиж танилцуулав.

Хурлын дарга: Дараагийн хэлэлцэх асуудал Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн тогтоолыг хэлэлцэж батлана. Та бүхэн санал байвал хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч М.Оюун. ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилахгүй гэсэн шийдвэр гаргасан дэмжиж байгаа. Гүйцэтгэх захирлын хувьд шалтгаанаа хурал дээр тайлбарлах ёстой. Иймээс цар тахалтай эдийн засаг хүнд байсан тул компани алдагдалтай ажилласан. Иймд ногдол ашиг хуваарилах боломжгүй. Цаашид эдийн засаг сайжирвал ногдол ашиг хуваарилах болно.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Асуудлыг дэмжиж байна.

Хурлын дарга: Өөр санал хүсэлт байхгүй бол санал хураалтаа явуулъя. Тооллогын комисс саналын хуудсаа хувьцаа эзэмшигчдэд тараана уу. Санал хураалт явагдаж дүнг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга Л.Энхсайхан танилцуулж, комиссоос гарах тогтоолоо танилцууллаа.

Хурлын дарга: Тооллогын комиссыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах тогтоолуудыг гаргахаар болж байна Та бүхэнд танилцуулъя.

Үүнд:

1. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны зардлын төсөв, дарга гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох тухай
4. ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүдийг сонгох тухай
5. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх
  - а. Ногдол ашгийн ТУЗ-ийн танилцуулга
  - б. Бусад

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигч та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье. Хурал 16:00 цагт өндөрлөж байна.

Хурлын дарга:

Хувьцаа эзэмшигч:

Б.Саруул

М.Цолмон

М.Оюун

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга  
/ Э.Жавхлантөгс /